



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Төсвийн хөрөнгө оруулалтын талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай:

1.1.хөрөнгө оруулалтын хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, журамд нийцүүлэн ил тод, шуурхай зохион байгуулан, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж, хүнд суртал гаргахгүй ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад;

1.2.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах хүрээнд газар олголтын асуудлыг шийдвэрлэн, газрын гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулах, нөхөх олговортойгоор газар чөлөөлөх ажлыг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг)-нд;

1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний архитектур төлөвлөлт, зураг төслийн даалгавар, техникийн тодорхойлолтыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааны эрх шилжсэн байгууллагуудад хүргүүлэхийг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), "Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат) болон захиалагчийн хяналт тавьж буй байгууллагын удирдлагуудад;

1.4.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөрт багтаан зарлаж дуусгахыг худалдан авах ажиллагааны эрх шилжсэн байгууллагын удирдлагуудад;

1.5. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэхийг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагуудад;

111020000150

1.6.улс, нийслэлийн төсөвт барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээг байгуулах, санхүүжилтийн олгох асуудлаар Ажлын хэсэг байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т;

1.7.Энэ захирамжийн 1.6-д заасан Ажлын хэсгийн хурлын шийдвэрийг тухайн төсөл, арга хэмжээний 2023 оны төсөвт батлагдсан үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт, магадлалын ерөнхий дүгнэлттэй нийцүүлэн, гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээ байгуулах, санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр нь зохих журмын дагуу олгохыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар), "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т тус тус;

1.8.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих байгууллага гаргахгүй байхыг холбогдох байгууллагын удирдлагуудад;

1.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр дамжуулан хэрэгжүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т;

1.10.нийслэлийн өмчид бүртгэхээр заасан төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу өмчид бүртгэх, эзэмшилт, ашиглалтыг хариуцан зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т, бий болсон хөрөнгийг өмчид бүртгэн авч, эзэнжүүлэхийг ашиглагч байгууллагын удирдлагуудад;

2.Нийслэлийн 2023 оны төсвийн орлогын бүрдүүлэлтийг жигд ханган биелүүлж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийг бүрдүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар), Нийслэлийн Татварын газар (Д.Батжаргал), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр), Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг), дүүргийн Засаг дарга нар болон бусад орлого бүрдүүлэгч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилтийн талаар сар тутам нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд, хагас жил тутам Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Х.Гантулга)-т даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР